



**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН САЙД**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Б.Ширэндэвийн гудамж 8/4, Засгийн газрын V байр,
Утас/Факс: (976-51) 26 75 33, И-мэйл: foreign@mojha.gov.mn,
Вэбсайт: www.mojha.gov.mn

2020.09.07 № 1-1/691
танай 2020.09.07-ны № 06 -Т

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН Ц.МӨНХЦЭЦЭГ ТАНАА**

Танаас ирүүлсэн 2020 оны “Асуулт тавих тухай” 06 дугаар албан бичигтэй танилцаж, холбогдох мэдээллийг хавсралтаар хүргүүлж байна.

Хүлээн авч, танилцана уу.

Хавсралт 13 хуудастай.



151600614
Доо.уам 85.2020

Хууль зүй, дотоод хэргийн
сайдын 2020 оны 09 дугаар
сарын 08-ны өдрийн 1-1/6.91
дугаар албан бичгийн хавсралт

ЦАХИМ ОРЧИНД ҮЙЛДЭГДСЭН ГЭМТ ХЭРГИЙН НӨХЦӨЛ БАЙДЛЫН ТАЛААРХ ТАНИЛЦУУЛГА


Нэг. Монгол Улсын хэмжээнд цахим орчинд үйлдэгдсэн нийт гэмт хэргийн
статистик, тоо баримт:

Нэг. Бүртгэгдсэн гомдол мэдээллийн талаар

1.1 Бүртгэгдсэн гомдол мэдээлэл

Монгол Улсын хэмжээнд иргэн, хуулийн этгээдээс цагдаагийн байгууллага 2018-2019 он, 2020 оны эхний 08 сарын байдлаар цахим орчинд үйлдэгдсэн 8253 гомдол мэдээлэл хүлээн авч хуульд заасан журмын дагуу шалгаж шийдвэрлэсэн. Хүлээн авсан гомдол мэдээллийг хугацаагаар нь авж үзвэл 2018 онд 2040, 2019 онд 3254, 2020 оны эхний 08 сард 2959 бүртгэгдсэн нь 2019 онд өмнөх оноос 1523 буюу 59.5 хувиар, 2020 оны эхний 08 сард өмнөх оны мөн үеийнхээс 1313 буюу 79.8 хувиар тус тус өссөн байна.

График 1. Гомдол, мэдээлэл




Гомдол, мэдээллийн төрлөөр нь авч үзвэл нийт гомдол мэдээллийн 4414 буюу 53.5 хувь нь гэмт хэргийн шинжтэй, 3839 буюу 46.5 хувь нь зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэл байгаа бөгөөд 6262 буюу 75.9 хувь нь Нийслэл хотод 1991 буюу 24.1 хувь нь орон нутагт бүртгэгдсэн байна.

График 2. Бүртгэгдсэн нутаг дэвсгэр



График 3. Бүртгэгдсэн гомдол мэдээллийн ангилал



Бүртгэгдсэн гомдол мэдээллийн ангиллаар нь авч үзвэл нийт бүртгэгдсэн гомдол мэдээллийн 2846 буюу 34.5 хувь нь Залилах, 1690 буюу 20.5 хувь нь Гүтгэх, 863 буюу 10.5 хувь нь Худал мэдээлэл тараах төрлийн гомдол мэдээллүүд тус тус эзэлж байна.

График 4. Гомдол мэдээллийн төрөл

| Д/д | Төрөл | 2018 он | 2019 он | 2020.08 | Нийт | Эзлэх хувь |
|-----|--|---------|---------|---------|------|------------|
| 1 | Залилах | 522 | 1373 | 951 | 2846 | 34.5 |
| 2 | Гүтгэх | 458 | 606 | 626 | 1690 | 20.5 |
| 3 | Худал мэдээлэл тараах | 188 | 211 | 464 | 863 | 10.5 |
| 4 | Худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээний журам зөрчих | 292 | 368 | 69 | 729 | 8.8 |
| 5 | Нэр төрд халдах | 68 | 81 | 122 | 271 | 3.3 |
| 6 | Хулгайлах | 102 | 102 | 47 | 251 | 3.0 |
| 7 | Компьютер мэдээллийн аюулгүй байдлын эсрэг | 59 | 64 | 83 | 206 | 2.5 |
| 8 | Далайлган сүрдүүлэх | 32 | 45 | 63 | 140 | 1.7 |
| 9 | Захидал харилцааны нууцад нэвтрэх, зохиогчийн эрхийн эсрэг | 46 | 28 | 37 | 111 | 1.3 |
| 10 | Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг | 26 | 54 | 25 | 105 | 1.3 |
| 11 | Компьютер мэдээллийн аюулгүй байдлын эсрэг | 14 | 31 | 54 | 99 | 1.2 |
| 12 | Садар самуунд уруу татсан | 4 | 12 | 7 | 23 | 0.3 |
| 13 | Дээрэмдэх | 10 | 3 | 3 | 16 | 0.2 |
| 14 | Хүчиндсэн | 5 | 2 | 6 | 13 | 0.2 |
| 15 | Бие үнэлэх, жуучлах, садар самуун сурталчлах | 4 | 2 | 6 | 12 | 0.1 |
| 16 | Бусад | 210 | 272 | 396 | 878 | 10.6 |

Тайлбар: Дээрх гэмт хэргүүдээс 2020 оны 08 дугаар сарын байдлаар бүртгэгдсэн "Хулгайлах*" төрлийн гэмт хэрэг нь цахим орчинд, цахим төхөөрөмж ашиглан иргэдийн интернет банкинд хууль бусаар нэвтэрч өөр данс руу мөнгө шилжүүлэн авсан үйлдэл.

Мөн "Хүчиндэх*" төрлийн гэмт хэрэг нь цахим орчинд хэн нэгэн этгээдтэй танилцаж улмаар харилцаа тогтоож хохирогчтой хүчээр бэлгийн харьцаанд орсон, эсхүл бэлгийн харьцааны шинжтэй хүч хэрэглэсэн үйлдэл.

“Дээрэмдэх*” гэмт хэрэг нь цахим орчинд эд зүйл худалдаалах зорилгоор зар оруулсны дагуу гэмт этгээд хохирогчийн эд зүйлийг хүч хэрэглэхгүйгээр болон хүч хэрэглэж, заналхийлж авсан үйлдлүүд нь тус тус цахим орчинд үйлдэгдсэн гэмт хэргүүд болж, Цагдаагийн ерөнхий газрын гэмт хэргийн санд орсон болно.

1.2 Гомдол, мэдээллийн шийдвэрлэлт

Бүртгэгдсэн гомдол мэдээллийн шийдвэрлэлтийг авч үзвэл гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийн 2171 буюу 49.2 хувьд эрүүгийн хэрэг үүсгэж, 2099 буюу 47.5 хувийг эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзаж, 7 буюу 0.2 хувийг ТЕГ-т шилжүүлж тус тус шийдвэрлэсэн бөгөөд 137 гомдол мэдээлэл ажиллагаанд байна.



График 5. Гомдол мэдээллийн шийдвэрлэлт




Зөрчлийн шинжтэй гомдол, мэдээллийн 2358 буюу 53.4 хувь нь Зөрчлийн хэрэг нээхээс татгалзсан, 777 буюу 17.6 хувийг зөрчлийн арга хэмжээ авч, 669 буюу 15.2 хувийг Зөрчлийн хэрэг нээхээс татгалзаж 29 буюу 0.7 хувийг ТЕГ-т шилжүүлж тус тус шийдвэрлэсэн бөгөөд 6 буюу 0.1 хувь нь шийдвэрлэгдээгүй байна.

Хоёр. Бүртгэгдсэн гэмт хэргийн талаар

2.1 Бүртгэгдсэн гэмт хэрэг

Улсын хэмжээнд 2015-2019 он, 2020 оны эхний 08 сарын байдлаар улсын хэмжээнд нийт 172.690 гэмт хэрэг бүртгэгдсэний 2781 буюу 1.6 хувь нь цахим орчинд үйлдэгдсэн байна. Цахим орчинд үйлдэгдсэн гэмт хэргийн он тус бүрээр нь харуулбал 2015 онд 61, 2016 онд 97, 2017 онд 195, 2018 онд 659, 2019 онд 737, 2020 оны эхний 08 сард 1032 тус тус бүртгэгдэж өсөлтийн дундаж хувь 92.4 хувь байна.

График 6. Цахим орчинд үйлдэгдсэн гэмт хэрэг



Хэрэг үйлдэгдсэн газраар нь авч үзвэл нийт бүртгэгдсэн энэ төрлийн гэмт хэргийн 2174 буюу 78.2 хувь нь нийслэл Улаанбаатар хотод, 589 буюу 21.2 хувь нь орон нутагт, 18 буюу 0.6 хувь нь хилийн чандад үйлдэгдсэн байна.

Үйлдэгдсэн газрыг он тус бүрээр нь харуулбал:

2015 онд бүртгэгдсэн гэмт хэргийн 52 буюу 85.2 хувь нь нийслэлд, 6 буюу 9.8 хувь нь орон нутагт, 3 буюу 5.0 хувь нь хилийн чанадад,

2016 онд бүртгэгдсэн гэмт хэргийн 73 буюу 75.3 хувь нь нийслэлд, 22 буюу 22.6 хувь нь орон нутагт, 2 буюу 2.1 хувь нь хилийн чанадад,


2017 онд бүртгэгдсэн гэмт хэргийн 147 буюу 75.4 хувь нь нийслэлд, 47 буюу 24.1 хувь нь орон нутагт, 1 буюу 0.5 хувь нь хилийн чанадад,

2018 онд бүртгэгдсэн гэмт хэргийн 519 буюу 78.8 хувь нь нийслэлд, 138 буюу 20.9 хувь нь орон нутагт, 2 буюу 0.3 хувь нь хилийн чанадад,

2019 онд бүртгэгдсэн гэмт хэргийн 555 буюу 75.3 хувь нь нийслэлд, 173 буюу 23.5 хувь нь орон нутагт, 9 буюу 1.2 хувь нь хилийн чанадад,

2020 оны эхний 08 сард бүртгэгдсэн хэргийн 828 буюу 80.2 хувь нь нийслэлд, 203 буюу 19.7 хувь нь орон нутагт, 1 буюу 0.1 хувь нь хилийн чандад тус тус бүртгэгдсэн байна


График 7. Цахим орчинд үйлдэгдсэн гэмт хэргийн бүртгэгдсэн газар



■ Нийслэл
■ Орон нутаг
■ Хилийн чандад


Нийслэлд бүртгэгдсэн 2781 гэмт хэргийн 880 буюу 31.6 хувь нь Баянзүрх дүүрэгт, 339 буюу 12.2 хувь нь Сүхбаатар дүүрэгт, 290 буюу 10.4 хувь нь Баянгол дүүргийн нутаг дэвсгэрт үйлдэгдсэн байна.

График 8. Нийслэлд бүртгэгдсэн гэмт хэрэг дүүргээр /2015-2019 он/



Орон нутгийн хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэргийн 95 буюу 16.1 хувь нь Дархан-Уул, 70 буюу 11.9 хувь нь Орхон, 46 буюу 7.8 хувь нь Өмнөговь аймагт тус тус бүртгэгдсэн нь бусад аймгуудаас өндөр байна.

График 9. Орон нутагт бүртгэгдсэн гэмт хэрэг аймгаар /2016-2019 он/



Бүртгэгдсэн гэмт хэргийн зүйл ангиар нь авч үзвэл нийт 39 төрлийн гэмт хэрэг цахим орчинд үйлдэгдсэн байх бөгөөд нийт хэргийн 2218 буюу 79.8 хувь нь Залилах, 232 буюу 8.3 хувь нь Цахим мэдээлэлд хууль бусаар халдах, 102 буюу 3.7 хувь нь Худал мэдээлэл тараах, 32 буюу 1.8 хувь нь Гүтгэх төрлийн гэмт хэргүүд тус тус эзэлж байна.

Энэ хугацаанд бүртгэгдсэн гэмт хэргийн дийлэнх хувийг эзэлж буй Залилах төрлийн гэмт хэрэг нь 2015 онд 17, 2016 онд 69, 2017 онд 136, 2018 онд 590, 2019 онд 641, 2020 оны эхний 08 сард 76 тус тус бүртгэгдсэн байна.

График 10. Бүртгэгдсэн гэмт хэрэг Эрүүгийн хуулийн зүйл ангиар.





График 11. Бүртгэгдсэн гэмт хэрэг Эрүүгийн хуулийн зүйл ангиар.

| Д/д | Төрөл | 2015 он | 2016 он | 2017 он | 2018 он | 2019 он | 2020.08 | Нийт |
|-----|---|---------|---------|---------|---------|---------|---------|------|
| 1 | Залилах | 17 | 69 | 136 | 590 | 641 | 765 | 2218 |
| 2 | Цахим мэдээлэлд хууль бусаар халдах | | | 39 | 43 | 53 | 97 | 232 |
| 3 | Худал мэдээлэл тараах | | | | | | 102 | 102 |
| 4 | Гүтгэх | 16 | 5 | 11 | | | | 32 |
| 5 | Доромжлох | 7 | 12 | 4 | | | | 23 |
| 6 | Хувь хүний нууцад халдах | | | | 14 | 7 | 4 | 25 |
| 7 | Компьютерын мэдээллийг хууль бусаар олж авах | 9 | 5 | 3 | | | | 17 |
| 8 | Хүүхдэд садар самууныг сурталчлах, уруу татах | | | | 5 | 7 | 3 | 15 |
| 9 | Компьютерын мэдээлэл, программыг өөрчлөх, эвдэх, сүйтгэх | 4 | 3 | 2 | | | 4 | 13 |
| 10 | Заналхийлэх | | | | | 7 | 15 | 22 |
| 11 | Мөрийтэй тоглоом зохион байгуулах | | | | | | 7 | 7 |
| 12 | Хувь хүний нууцыг задруулах | | | | 5 | 1 | 2 | 8 |
| 13 | Алдаатай гүйлгээ, андуурагдсан илгээмж, гээгдэл эд хөрөнгө, алдуул мал завших | | | | | 4 | 7 | 11 |
| 14 | Хулгайлах | | | | | | 4 | 4 |
| 15 | Нянтай программ зохион бүтээх, ашиглах, тараах | 2 | 1 | | | | 1 | 4 |
| 16 | Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийг зөрчих | | | | 2 | 1 | 1 | 4 |
| 17 | Мөнгө угаах | | | | | 3 | 1 | 4 |
| 18 | Дээрэмдэх | | | | | | 2 | 2 |
| 19 | Садар самууныг сурталчилах | 2 | | | | | | 2 |
| 20 | Бусдын бие махбодид хөнгөн гэмтэл санаатай учруулах | 2 | | | | | | 2 |

| | | | | | | | | |
|----|---|----|----|-----|-----|-----|------|------|
| 21 | Хуурамч баримт бичиг үйлдэх, ашиглах | | | | | 2 | 1 | 3 |
| 22 | Хүчиндэх | | | | | 2 | 3 | 5 |
| 23 | Арван зургаан насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харьцаанд орох | | | | | 2 | 3 | 5 |
| 24 | Бусдын эд хөрөнгийг авахаар заналхийлэх | | | | | 2 | 4 | 6 |
| 25 | Бэлгийн мөлжлөг | | | | | 1 | | 1 |
| 26 | Хүн худалдаалах | | | | | 1 | | 1 |
| 27 | Ялгаварлан гадуурхах | | | | | 1 | | 1 |
| 28 | Бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах | | | | | 1 | | 1 |
| 29 | Хууль бусаар даатгалын нөхөн төлбөр авах | | | | | 1 | | 1 |
| 30 | Хууль бусаар мөрдөж мөшгих | | | | | | 1 | 1 |
| 31 | Сонгуулийн үеэр илт худал мэдээлэл тараах | | | | | | 1 | 1 |
| 32 | Барааны тэмдэг эзэмшигч, газар зүйн заалт хэрэглэгчийн эрхийг зөрчих | | | | | | 1 | 1 |
| 33 | Мөнгөн тэмдэгт, үнэт цаас, төлбөр тооцооны хэрэгсэл хуурамчаар бэлтгэх, ашиглах | | | | | | 1 | 1 |
| 34 | Худал мэдүүлэх | | | | | | 1 | 1 |
| 35 | Мөрдөн шалгах ажиллагааны нууцыг задруулах | | | | | | 1 | 1 |
| | Нийт | 59 | 95 | 195 | 659 | 737 | 1032 | 2777 |

Гэмт хэрэг үйлдэгдсэн шалтгаанаар нь авч үзвэл нийт бүртгэгдсэн гэмт хэргийн 61.1 хувь нь ашиг олох, шунахайн сэдэлтээр, 23.4 хувь нь итгэл эвдэх, 2.4 хувь нь цахим мэдээллийн аюулгүй байдал, нууцлал хангалтгүй, 1.8 хувь нь хяналт шалгалт сул байгаатай холбоотой байна.

График 12. Гэмт хэрэг үйлдэгдсэн шалтгаан. /2015-2019 он, 2020 оны эхний 08 сар/



2.2 Гэмт хэрэгт холбогдогч


Энэ төрлийн гэмт хэрэгт сүүлийн 5 жилийн байдлаар нийт 311 хүнийг 1091 хэрэгт холбогдуулан шалгасны 2015 онд 50 хүнийг 53 хэрэгт, 2016 онд 38 хүнийг 54 хэрэгт, 2017 онд 27 хүнийг 63 хэрэгт, 2018 онд 42 хүнийг 157 хэрэгт, 2019 онд 69

хүнийг 343 хэрэгт, 2020 оны эхний 08 сард 85 хүнийг 421 хэрэгт тус тус холбогдуулан шалгасан байна.

2016 онд сэжигтнээр татсан хэргийг 2015 онтой харьцуулбал 1.9 хувиар, 2017 оны хэргийг 2016 онтой харьцуулбал 16.7 хувиар, 2018 онд яллагдагчаар татсан хэргийг 2017 онтой харьцуулбал 2.5 дахин, 2019 онд яллагдагчаар татсан хэргийг 2018 онтой харьцуулбал 2.2 дахин тус тус өссөн байна.


Харин 2016 онд сэжигтнээр татсан хүнийг 2015 онтой харьцуулбал 24.0 хувиар, 2017 оны сэжигтнийг 2016 онтой харьцуулбал 28.9 хувиар тус тус буурч, 2018 онд тухайн хэрэгт холбогдогчдыг 2017 онтой харьцуулбал 55.6 хувиар, 2019 оны холбогдогчдыг 2018 онтой харьцуулбал 64.3 хувиар тус тус өссөн байна.

График 13. Гэмт хэрэг, холбогдогч



Холбогдогчдыг хүйсээр нь авч үзвэл 2015 онд холбогдсон хүний 32 буюу 64.0 хувь нь эрэгтэй, 18 буюу 36.0 хувь нь эмэгтэй, 2016 онд холбогдсон хүний 27 буюу 71.1 хувь нь эрэгтэй, 11 буюу 28.9 хувь нь эмэгтэй, 2017 онд холбогдсон хүний 22 буюу 81.5 хувь нь эрэгтэй, 5 буюу 18.5 хувь нь эмэгтэй, 2018 онд холбогдсон хүний 37 буюу 88.1 хувь нь эрэгтэй, 5 буюу 11.9 хувь нь эмэгтэй, 2019 онд холбогдсон хүний 57 буюу 82.6 хувь нь эрэгтэй, 12 буюу 17.4 хувь нь эмэгтэй, 2020 эхний 08 сард холбогдсон хүний 62 буюу 72.9 хувь нь эрэгтэй, 23 буюу 27.1 хувь нь эмэгтэй хүн байна.


График 14. Гэмт хэрэгт холбогдогчдын хүйс



2.3 Гэмт хэргийн улмаас учирсан хохирол

Цахим орчинд үйлдэгдсэн гэмт хэргийн улмаас нийт 2524 хүн хохирсноос 2015 онд 65, 2016 онд 82, 2017 онд 129, 2018 онд 681, 2019 онд 711, 2020 оны эхний 08 сард 856 хүн хохирсон байна.


График 15. Цахим орчинд үйлдэгдсэн гэмт хэргийн хохирогч /2015-2019, 2020 оны эхний 08 сар/



2016 онд хохирсон хүнийг 2015 оныхтой харьцуулбал 26.2 хувиар, 2017 онд хохирсон хүнийг 2016 онтой харьцуулбал 57.3 хувиар, 2018 оны хохирсон хүнийг 2017 онтой харьцуулбал 5.3 дахин, 2019 оны хохирсон хүнийг 2018 онтой харьцуулбал 4.4 хувиар тус тус өссөн байна.


Хохирогчдын хүйсээр нь авч үзвэл энэ хугацаанд нийт хохирогчдын 1246 буюу 49.4 хувь нь эрэгтэй, 1278 буюу 50.6 хувь нь эмэгтэй байгаагаас 2015 онд хохирсон хүний 26 буюу 40.0 хувь нь эрэгтэй, 39 буюу 60.0 хувь нь эмэгтэй, 2016 онд хохирсон хүний 51 буюу 62.2 хувь нь эрэгтэй, 31 буюу 37.8 хувь нь эмэгтэй, 2017 онд хохирсон хүний 56 буюу 43.4 хувь нь эрэгтэй, 73 буюу 56.6 хувь нь эмэгтэй, 2018 онд хохирсон хүний 310 буюу 45.4 хувь нь эрэгтэй, 371 буюу 54.6 хувь нь эмэгтэй, 2019 онд хохирсон хүний 315 буюу 44.3 хувь нь эрэгтэй, 396 буюу 55.7 хувь нь эмэгтэй, 2020 оны эхний 08 сарын хохирогчдын 368 буюу 43.0 хувь нь эмэгтэй, 488 буюу 57.0 хувь нь эрэгтэй хохирогч нар байна.

График 16. Гэмт хэрэгт хохирогчдын хүйс



Насны ангиллаар нь авч үзвэл нийт хохирогчдын 574 буюу 22.7 хувь нь 30-34 насны, 382 буюу 15.3 хувь нь 25-29 насны, 383 буюу 15.2 хувь нь 35-39 насны иргэд эзэлж байна.

График 17. Хохирогчдын насны ангилал, хүйс /2015-2019, 2020 оны эхний 08 сар/



Хоёр. Цахим орчинд хүний эрхийг хангах, хамгаалах чиглэлээр батлагдсан хууль тогтоомжийн хэрэгжилтийн явц байдал:

Цагдаагийн байгууллага нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүргийг хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажуулсан хүний эрх, эрх чөлөө, нийтийн болон үндэсний ашиг сонирхол, Үндсэн хуулийн байгуулал, үндэсний болон хүн төрөлхтний аюулгүй байдлыг гэмт халдлагаас хамгаалах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг хэрэгжүүлж байна.

Цагдаагийн байгууллагад хуулиар хүлээлгэсэн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд аюулгүй цахим орчинг бий болгох зорилгоор дараах ажил, арга хэмжээг зохион байгуулсан. Үүнд:

Гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгах, өсвөр насны хүүхдийг цахим орчинд үйлдэгдэж буй гэмт хэрэг, зөрчил бусад эрсдэлт хүчин зүйлээс урьдчилан сэргийлэх, хамгаалах, цахим орчин дахь зохистой хэрэглээг бий болгох, хяналт тавих, иргэдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх зорилготой “UNFRIEND хөдөлгөөн”-ийг зохион байгуулсан.

Тус хөдөлгөөний хүрээнд 2018 онд Төрийн ордны их танхимд төрийн болон төрийн бус байгууллагын төлөөлөл, оюутан, сурагчид зэрэг 800 хүн оролцуулсан “Таны хүүхдийг танихгүй хүмүүс хүмүүжүүлж байна” сэдэвт нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулж, хэлэлцүүлгээс гарсан зөвлөмжийг Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд нарт гардуулан өгсөн.

Иргэдийн эрх зүйн мэдлэг, боловсролыг дээшлүүлэх, анхааруулга, сэрэмжлүүлэг агуулга бүхий 15 видео контент бүтээж олон нийтийн цахим сүлжээгээр түгээснийг давхардсан тоогоор 3,465,293 хүн үзэж, 47,791 хүн бусадтай хуваалцаж, 36,829 хүнд таалагдаж, 2,552 сэтгэгдэл үлдээсэн байна. Дээрх

контентуудыг 31 телевизүүдээр түгээснийг 318,720¹ хүн үзжээ. Анхааруулга, сэрэмжлүүлэг, мэдээлэл бүхий 51 зурагт мэдээг олон нийтийн цахим сүлжээнд нийтэлснийг 813,165 хүн үзэж 7,142 хүнд таалагдаж, 5,794 хүн бусадтай хуваалцан, 398 сэтгэгдэл үлдээжээ.

Оюутан, сурагчдад зориулж “Цахим орчны талаар таны мэдэхгүй үнэн” сэдэвт сургалтын хичээл бэлтгэж Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамаар дамжуулан сургалт зохион байгуулсан бөгөөд уг сургалтад ерөнхий боловсролын 65 сургуулийн 72751 сурагч, 15 их, дээд сургууль, коллежийн 2385 оюутан хамрагдсан.

Залилах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх “Ятгах тусам нягтал” арга хэмжээний хүрээнд видео контент 8, сэрэмжлүүлэх потсер 27, хэвлэлийн мэдээ 12, гэрч, хохирогчийг хамгаалах үйл ажиллагааны талаар видео контент 4, байгууллага, алба хаагчийн үйл ажиллагааны талаар хэвлэлийн мэдээ 6, хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх 2 постер, 1 видео контент, зам, тээврийн осол хэргээс урьдчилан сэргийлэх хэвлэлийн мэдээ 2, видео контент 2-ыг тус тус бэлтгэн олон нийтийн цахим сүлжээнд байршуулан түгээсэн.

Залилах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх “Ятгах тусам аюулгүй” арга хэмжээний хүрээнд бүтээсэн ухуулга нөлөөллийн видео контент 8, сэрэмжлүүлэх мэдээлэл 4, нөлөөллийн постер 8, хэвлэлийн мэдээлэл 3-ыг пэйж хуудас, твиттер хуудаст байршуулж олон нийтэд түгээх ажлыг зохион байгуулсан.

Гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр: Цахим орчинд хүний эрхийг хангах, хамгаалах чиглэлд хамаарах Эрүүгийн хуулийн тусгай ангид 13.10 дугаар зүйл “Хувь хүний нууцад халдах”, 13.11 дүгээр зүйл “Хувь хүний нууцыг задруулах”, 13.12 дугаар зүйл “Хууль бусаар мөрдөж мөшгих”, 13.14 дүгээр зүйл “Худал мэдээлэл тараах”, 16.9 дүгээр “Хүүхэд оролцуулж садар самууныг сурталчлах”, 17.3 дугаар зүйл “Залилах”, 26 дугаар зүйл “Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг” зэрэгт заасан нийт 8253 гомдол, мэдээллийг 2018 оноос 2020 оны эхний 08 дугаар сар хүртэлх хугацаанд хүлээн авч холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулан, хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Мөн Монгол Улсын Эрүүгийн хуульд 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрөөс нэмэлт өөрчлөлт орж мөрдөгдөх болсонтой холбогдуулан уг хуульд шинээр орсон Эрүүгийн хуулийн 20.17 дугаар зүйл /Мерийтэй тоглоом зохион байгуулах/, 12.6 дугаар зүйл /Биеэ үнэлэхийг зохион байгуулах/, “Зөрчлийн тухай хууль”-ийн 6.18 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан үйлдлүүдийг зөрчин цахим орчинд хууль бус үйл ажиллагаа явуулж байсан нэр бүхий 112 вэб сайт, 187 фэйсбүүк хуудас групп, “Садар самуунтай тэмцэх тухай хууль”, “Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль”, “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль”, “Эрүүгийн хууль”-ийн холбогдох заалтыг зөрчсөн үйл ажиллагаа явуулж байсан 19 вэб сайт, 7 домайн хаягт Монгол Улсаас хандах эрхийг хязгаарлах ажлыг Харилцаа холбооны зохицуулах хороотой хамтран зохион байгуулсан.

Гурав. Цахим орчны аюулгүй байдлыг нэмэгдүүлэх, цахим орчинд хүний эрхийг хангахад шаардлагатай хуулийн төсөлд өгөх санал, цаашид төрөөс баримтлах бодлогын талаар:

¹ Максима Консалтинг ХХК-ний тайлан

Нэгдсэн Үндэсний Байгууллагаас “Кибер гэмт хэрэг нь үндэстэн дамнасан, зохион байгуулалттай гэмт хэрэг бөгөөд уг гэмт хэргийг үйлдэгч болон хохирогч нь дэлхийн өнцөг булан бүрт байрлаж, интернет орчноор дамжин өөр хоорондоо холбогддог тул олон улсын хамтын ажиллагаа зайлшгүй шаардлагатай гэмт хэрэг юм” гэж тодорхойлсон.

Мөн олон улсын эрүүгийн цагдаагийн байгууллага /Интерпол/-аас “Кибер гэмт хэрэг гэдэг нь сонгодог утгаараа компьютер болон мэдээллийн сүлжээнд хууль бусаар хандалт хийх эсхүл хууль ёсны хэрэглэгчээс хийх хандалтыг тасалдуулах зорилгоор компьютер болон мэдээллийн сүлжээг халдлагын зүйлээрээ сонгон үйлдэгддэг, маш эрчимтэй хувьсан өөрчлөгдөж, шинэ үйлдлийн аргууд тогтмол илэрч, бүртгэгдэж байгаа гэмт хэрэг” гэж тодорхойлсон бөгөөд гэмт бүлэглэлүүд хууль бус үйл ажиллагаагаа хөнгөвчлөх, богино хугацаанд их ашиг олох зорилгоор интернетийг өргөнөөр ашиглах болсонтой холбоотойгоор хулгайлах, гүтгэх, хүүхдийг садар самуунд уруу татах, залилах, хууль бус мөрийтэй тоглоом, хуурамч эмийн худалдаа зэрэг уламжлалт гэмт хэргүүд цахим орчинд үйлдэгдэх болсон тул цагдаа, хууль сахиулах байгууллагууд кибер гэмт хэргээс гадна кибер орчинд үйлдэгдэж байгаа энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлд анхаарах шаардлагатай байгааг онцлон тэмдэглэсэн байна.

Харилцаа, холбооны зохицуулах хорооны албан ёсны веб сайтад тавигдсан мэдээллээр 2012 онд манай улсад интернэт хэрэглэгчдийн тоо 654 мянга байсан бол 2017 онд 2.9 сая, 2018 онд 3.1 саяд хүрч, 4.5 дахин нэмэгджээ. Монгол Улс өнөөдрийн байдлаар фейсбүүк хэрэглэгчдийн тоогоор Ази тивд 1 дүгээрт /2.2 сая/, дэлхийд 10 дугаар байрт жагсах болсон нь цахим хэрэглээний хамрах хүрээ, хэрэглээ тус улсад хурдацтай өсч байгааг харуулж байна.

Цахим хэрэглээний хамрах хүрээ, хэрэглээ хурдацтай өсч байгаа нь сайн үзүүлэлт боловч гадаад улсад байрлах платформуудад иргэдийн их хэмжээний өгөгдөл, мэдээлэл хадгалагдаж байгаа нь үндэсний аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж болзошгүй нөхцөл үүссэн гэж дүгнэж болохоор байна.

Мөн цахим хэрэглээг даган бусдын нэр төр, алдар хүндэд халдах, гутаан доромжлох, иргэдийг залилан мэхлэх, төөрөгдүүлэх, үзэл бодлоор нь талцуулах, хүчирхийлэлд уриалах, мансуурал, садар самуун явдлыг сурталчлах, мөрийтэй тоглоом тоглуулах зэрэг гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй хууль бус үйлдлүүд эрс ихсэх хандлагатай болсон бөгөөд иргэд болон төрийн байгууллагууд мэдээллийн аюулгүй байдалд төдий анхаардаггүй, энэ чиглэлээр мэргэшсэн мэргэжилтэн дутмаг, албан ёсны эрхтэй програм хангамж /үйлдлийн систем, хэрэглээний болон вирусны эсрэг програм хангамж/-уудыг хэрэглэдэггүй, мэдээллийн аюулгүй байдлыг хангахад шаардагдах зардлыг төсөвт тусгадаггүй зэрэг нь халдлагад өртөх боломжийг бий болгож байна.

Иймд цахим орчинд хүний эрхийг хангах, мэдээллийн аюулгүй байдлыг нэмэгдүүлэх зорилгоор дараах ажил, арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзэж байна. Үүнд:

-Цахим орчинд иргэдийг таних, харилцан мэдээлэл солилцох, хүний эрхийг хамгаалах, мэдээллийн аюулгүй байдлыг хангах эрх зүйн орчныг боловсронгуй

болгох чиглэлээр хуулийн төслүүдийг холбогдох байгууллагууд боловсруулсан бөгөөд уг хуулиудыг Улсын Их Хуралд өргөн барьж, батлуулах;

-Цахим орчины аюулгүй байдлыг хангах чиглэлээр Будапештын Конвенцод нэгдэж, /Convention on Cyber-crime/ уг конвенцод нэгдэн орсон бусад гадаад улстай хамтран ажиллах;

-Төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран бүх насны иргэд, хуулийн этгээдүүдийн цахим хэрэглээний боловсролын түвшинг нэмэгдүүлэх, цахим орчин дахь аюулгүй байдлыг хангах анхан шатны мэдлэг, дадлыг олгох;

-Кибер гэмт хэрэг, цахим орчин дахь аюул заналаас урьдчилан сэргийлэх мэдээллийг түргэн хугацаанд өргөн хэмжээгээр түгээх дэд бүтцийг бий болгох;

-Монгол Улсын интернэт урсгалын ажиглалтын систем /content monitoring/-ийг бий болгож, дүн шинжилгээ хийх нөхцөл боломжийг бүрдүүлэх;

-Интернэт үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудтай хамтран байнгын нээлттэй утасгүй интернэтийн холболт /free wifi/-уудад нэвтрэх зөвшөөрөл, бүртгэлийн дэд бүтцийг бий болгох;

-Интернэт кафе, цахим тоглоомын газруудад үйлчлүүлэгчийн бүртгэл, интернэт хандалтын түүх, дамжиж буй интернэт урсгалыг хянах, бүртгэх нөхцөлийг бүрдүүлэх;

-“Цахим орчин хүний эрхийг ханган, аюулгүй цахим орчинг бий болгох” өдрийг бий болгож, энэ чиглэлд мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх зэрэг болно.

--oOo--